



ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж.ЭРДЭНЭБАТ
ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2016.03.15 № 3/455

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хөдөө Аж ахуйн бирж ХХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөдөө Аж ахуйн бирж ХХК-ийн удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж тайлагнах үүрэг хариуцлага хүлээнэ.

Хөдөө Аж ахуйн бирж ХХК-ийн 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хөдөө Аж ахуйн бирж ХХК-ийн 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

\\10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2016\0315SAG65.Docx

078332

Регистрийн дугаар

5	6	7	4	5	2	2
---	---	---	---	---	---	---

Хаяг: Сүхбаатар дүүрэг 8-р хороо Бээжингийн гудамж 37, GB Plaza 7 давхар

Шуудангийн хаяг: Сүхбаатар дүүрэг 8-р хороо Бээжингийн гудамж 37, GB Plaza 7 давхар

Утас: 70148779

Факс: (976-11) 70138779

Өмчийн хэлбэр:

Төрийн 100 хувь

Хувийн _____ хувь



**"Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ИЙН
2015 ОНЫ ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Хянаж хүлээн авсан байгууллагын нэр	Сар, өдөр	Гарын үсэг
<i>УБ-Сэлжэр</i>	<i>14/27</i>	<i>[Signature]</i>

ГЭРЭЛТ ХӨХИЙН
ТЭНЦВЭР АУДИТ

